

НЭГ АЛХАМ УРАГШ, НЭГ АЛХАМ ХОЙШ

*Т.Залаа-Уул**

Өнөөгийн Монгол Улс Румыний хооронд дипломат харилцаа өнгөрсөн зууны 1950 оны 4 дүгээр сарын 29-нд тогтсон байна. Гэвч бидний мэдэх түүхэн эх сурвалжид Монгол, Румыний харилцааны талаар арай тод томруун тэмдэглэн үлдээсэн нь XIII зуунд хамаардаг. 1240 оны өвөл Унгарын нийслэлийн зүүн хэсэг Пештийг эзлэн авч Дунай мөрөнд тулан очсон Их Чингис хааны ач хүү Бат хааны цэрэг зам зууртаа тэр үеийн Румыний вант улсуудыг түрэмгийлэн цохиж, ихээхэн хор хохирол учруулсан ба 1241 онд Монголын нийслэл Хархорин хотноо Өгөөдэй хаан таалал төгссөн тул тэрээр буцах болж, цэргээ татсан тухай хоёр талын түүхэн эх сурвалжуудад тэмдэглэжээ. Үүнээс үзвэл Монгол, Румыний харилцааны түүх аль эртнээс эхтэй ажгуу. Юутай ч эл үйл явдлаас хойш “Монгол гэдэг нэгэн нэр” Румынд мартагдаагүй явсаар XX зууны хоёрдугаар хагастай золгож, хоёр орон жинхэнэ ёсоор харилцаа холбоо тогтоосон байх юм.

Дэлхий ертөнц хоёр өөр системд хуваагдан хүйтэн дайны үнэр ханхалж эхэлсэн 1950-иад онд Монгол Улс чухамхүү “Их ах” ЗХУ-ын зөвлөгөө, зуучлалаар Төв болон Дорнод Европт үүсэн буй болсон “ардын ардчилсан” орнуудтай, түүний дотор БНРумын Ард Улстай дипломат харилцаа тогтоосон юм. Дайнд ялсан, ажилчин-тариачны ЗСБНХУ-ын марксист-ленинист нийгэм, улс төрийн тогтолцоог хуулан авч социализмын замаар замнахаар эгнэгт шийдсэн манай орнуудын хувьд бие биеэ дэмжин, цаашилбал коммунист системийг цогцлон бүрэлдүүлэх нь тэр үедээ амин чухал зорилт болж байжээ. Энэ л зорилгын үүднээс Монгол, Румыний харилцаа, хамтын ажиллагаа 40-өөд жил коммунизмын түүхийн эрээн барааныг туучин хөгжиж ирсэн билээ. Монгол Улс 1963 онд Бухарестэд, Румын улс 1965 онд Улаанбаатарт тус тус ЭСЯ-даа нээж, харилцаа нэг алхам урагшилсан гэж хэлж болно.

Хагас зууныг элээсэн Монгол, Румыний харилцааг түүхэн хөгжил, үйл явдлын өрнөл, зангилааг үндэслэн 4 үе шатанд хуваан авч үзэж болох юм. Үүнд:

Нэгдүгээрт 1950 оноос 1971 он буюу *хөгжлийн жилүүд*,
Хоёрдугаарт 1971 оноос 1983 он буюу *хүйтрэлийн жилүүд*,
Гуравдугаарт 1983 оноос 1989 он буюу *өөрчлөлтийн жилүүд*
Дөрөвдүгээрт 1989 оноос хойш буюу *зах зээлийн жилүүд*

*Т.Залаа-Уул - Монголын дипломат албаны тэргүүн шадар

Хөгжлийн жилүүд

Нэгдүгээр үе шат буюу хөгжлийн жилүүдэд Монгол, Румыний харилцаа, хамтын ажиллагаанд томоохон дэвшил гарч, орчин үеийн харилцааны үндэс суурь бүрэн тавигдсан гэж үзэж болно. Улс төрийн харилцааны салбарт анхны дээд хэмжээний айлчлал, уулзалтууд болж, худалдаа, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн харилцааны эрх зүйн хийгээд сэтгэл зүйн үндэс бүрдсэн юм. Тухайлбал, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн \СнЗ\ дарга Ю.Цэдэнбал тэргүүтэй нам, засгийн төлөөлөгчид Румынд 1957 онд албан ёсны найрсаг айлчлал хийж, Румыний СнЗ-ийн дарга Петру Гроза, РКН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Георге Георгиу Деж нартай албан ёсны хэлэлцээ яриа хийн, хоёр талын “ах дүүгийн” харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхээр тохиролцжээ.

Анхны худалдааны хэлэлцээрийг 1958 онд байгуулсан бөгөөд 1969 онд уг салбарт байнга мөрдөх урт хугацааны суурь хэлэлцээр болгон өөрчилсөн байна. Монгол Улс 1958 оноос Румынд малын гаралтай түүхий эд экспортолж, оронд нь чихэр жимс, хүнсний ногооны нөөш, өргөн хэргэлээний бараа бүтээгдэхүүн авч эхэлсэн ажээ.

Мөн боловсрол, соёлын харилцааны суурь тавигдаж, анхны оюутан, урлагийн хэсэг Румынд илгээж, Румынээс ч мөн соёл, боловсрол, ШУ-ны байгууллагын төлөөлөгч ирж, хүмүүнлэгийн харилцааны эхлэл тавигдсан байна.

Төр, засаг, нам, олон нийтийн байгуулагуудын хооронд харилцаа холбоо тогтоож, төлөөлөгч зочид харилцан солилцож, тус тусын орны хөгжил бүтээн байгуулалттай танилцах ажил ид өрнөсөн жилүүд чухамдаа 1960-1970-аад он байжээ. 1949 онд байгуулагдсан социалист системийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага – Эдийн Засгийн Харилцан Тусалцах Зөвлөл \ЭЗХТЗ\ -д Монгол Улс 1962 онд элссэнээр энэ чиглэлийн “уялдуулан зохицуулсан” бодлогын хүрээнд хамрагдаж, гишүүн орнууд, түүний дотор Румын улстай харилцаа, хамтын ажиллагаа улам өргөжин тэлсэн байна.

Харин 1965 онд Г.Деж нас барсны дараа Николае Чаушеску Румыний коммунист нам, төрийн тэргүүн болсон нь ЗХУ болон социалист системийн зарим орны “толгойн өвчин” болсон түүхтэй. Н.Чаушеску үндэсний үзэл, ЗХУ-аас хараат бус байх бодлогыг дэмжиж, түүнийг баримтлахаа удаа дараа намынхаа дотор битүү илэрхийлж байсан нь дэмжлэг хүлээн гарч ирэхэд нь чухал түлхэц болсон гэж судлаачид үздэг. Түүнийг гарч ирсэнд Зөвлөлтийн удирдлага нэн сэтгэл таатай бус байсан ажээ. Энэ уур амьсгал Зөвлөлтийн дагуул улс Монголын коммунист удирдагчдад ч нөлөөлсөн нь дамжиггүй. Нөгөө талаар Н.Чаушеску дэлхийн бүх “ардчилсан” улстай, түүний дотор

БНХАУ-тай найрамдал, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх чиг шугам баримталж байсан нь ЗХУ, БНХАУ-ын харилцаа нэн хурцдаад байсан тэр цаг үед “социалист хамтын нөхөрлөлийн” орнуудын, тэр дундаа Монголын коммунист удирдагчдын чихийг дэлдийлгэж, шарыг нь хөдөлгөдөг байжээ. Иймээс Румыний удирдагчдад үл итгэх байдал буй болж, тэр нь харилцаанд нөлөөлсөөр ирсэн юм. 1968 онд Варшавын Гэрээний орнуудын зэвсэгт хүчин Чехословакт довтлоход Румын оролцоогүйгээр үл барам тэр түрэмгийллийг эрс тууштай шүүмжилсэн нь “дайран дээр давс” асгасан ажээ. Түүхийн ийм ээдрээ төвөгтэй цаг үе буюу 1971 онд Н.Чаушеску, гэргийн хамт БНХАУ, БНАСАУ-д албан ёсны айлчлал хийхдээ мөн Монгол оронд хүрэлцэн ирсэн билээ.

Энэ үед Монгол, Румыний харилцаанд чамгүй дэвшил гарсан байлаа. Худалдааны эргэлт тогтмолжиж, эдийн засгийн хамтын ажиллагааны тодорхой төслүүд яригдаж эхэлсний дотор Румыний техник, эдийн засгийн туслалцаа дэмжлэг, зээлийн хөрөнгөөр Улаанбаатар хотноо Улсын циркийн барилга бариулах ажил өрнөж байв. Монгол Улс Румынд уран барилга, ХАА, биологи, нефть химийн чиглэлээр оюутан суралцуулахаар илгээж, соёл, спортын арга хэмжээнд харилцан төлөөлөгчид оролцуулан, дунд сургуулийн сурагчид зусланд амруулахаар хүртэл солилцох болсон байв.

Зөвлөлтийн удирдагчдын баримталж байсан чиглэлийг Монгол Улс сохроор хэлбэрэлтгүй даган мөрддөг байснаас Румын зэрэг тухайн үедээ олон улсын харилцааны асуудлаар эрүүл саруул бодлого баримталж байсан орнуудтай эрс зөрчилддөг байжээ. Чухам ийм үйл явдал Н.Чаушеску, түүний гэргий Еленагийн 1971 онд Монголд хийсэн айлчлалын үеэр болсон байдаг. Чаушеску тэргүүтэй төлөөлөгчдийн Ю.Цэдэнбал болон Монголын удирдагчидтай хийсэн албан ёсны хэлэлцээ яриа тун ширүүн дориун болжээ. Учир нь тухайн үед тогтсон байсан заншлаар хоёр дарга эхлээд улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжил, байдлын талаар харилцан мэдээлж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны тухай санал солилцсоны дараа олон улсын харилцааны тухайн үеийн тулгамдсан асуудлаар байр сууриа мөн харилцан тайлбарладаг байжээ. Чухам эндээс “хэрүүл хараал” эхэлсэн байна. Н.Чаушеску БНХАУ-д айлчлаад буцаж байсан тул Мао даргын мэндчилгээг Цэдэнбалд уламжлахын сацуу, түүний байр суурийг тайлбарлаж, “Монгол Улс хөрш хоёр орныхоо хэн нэгний талыг баримтлахгүйгээр хоёуланттай нь сайн харилцаатай байх нь хөгжил дэвшилд нь хэрэгтэй” гэсэн зөв санааг хэлсэн байдаг. Гэтэл Хятад болон Мао даргад угаас “алергитэй” Цэдэнбал дарга түүний хэлснийг эрс буруушааж, “Хятадын ревизионистүүдийг” хурц шүүмжилсэн ажээ. Уг нь Н.Чаушеску тухайн үед ЗХУ, БНХАУ-ын удирдагчдын хоорондын

зөрчилдөөнөөс болж эрс хурцадсан Монгол, Хятадын харилцааг сайжруулах зорилгоор зуучийн үүрэг гүйцэтгэх санаатай байсан ч гэж ярьдаг. Үүнээс гадна тухайн үеийн олон улсын харилцааны гол асуудлууд, Чехословак, Кампучи, Вьетнам, Ойрхи Дорнод, Коммунист ажилчны хөдөлгөөний гэх зэрэг сэдвүүдээр хоёр тал эрс өөр өөр байр суурьтай байжээ. Монголын хувьд Зөвлөлтийн байр суурийг л давтдаг байсан цаг. Тухайлбал, Н.Чаушеску Варшавын гэрээний зэвсэгт хүчин Чехословакт довтолж, цус урсган, нэгнийхээ дотоод хэрэгт бүдүүлгээр оролцсон явдлыг эрс буруушаахад Ю.Цэдэнбал үүнийг зөвтгөж, “Чехословакын ард түмний хүсэлтээр” хийгдсэн хэмээн хамгаалж байжээ. Ийм ийм зөрөлдөөний улмаас яриа хэлэлцээ амжилтгүй болж, тэр бүү хэл Цэдэнбал, Чаушеску нар хэрэлдэж, албан ёсны айлчлалын арга хэмжээнүүд ч тасалдахад хүрсэн байна. Хөтөлбөрт орсон “Монгол, Румыний найрамдлын цуглаан” цагаас их хоцорч хүмүүсийг чилээснээс гадна Цэдэнбал, Чаушеску нар товч үг хэлсэн болоод өнгөрсөн ажээ. Монгол, Румыний харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж, Монголын тал Чаушескуг Сүхбаатарын одонгоор шагнахаар төлөвлөж байсан нь ч талаар болсон. Тэр нь Чаушеску эхнэр Елена Чаушескуг мөн шагнуулахаар зүтгэснээс болсон хэмээн тухайн үед Монголын тал тайлбарлаад өнгөрсөн ажээ. Ийнхүү Монгол, Румыний орчин үеийн харилцаа түүхэндээ анх удаа ихээхэн муудаж, итгэлцэл эвдрэн энэ нь цааш цаашдын хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлж, “хүйтрэлийн жилүүд” эхэлсэн түүхтэй.

Хүйтрэлийн жилүүд

Н.Чаушескугийн 1971 оны домогт айлчлалын дараа Монголд ч Румынд ч бие биеэ муулах, харилцан баримталсан байр сууриа коммунист нам, ард түмнээрээ дэмжүүлэх гэсэн дарангуйлагч нарын компани түймэр адил дэгдсэн байна. Үүнийг МАХН, РКН хоёул нүсэр том дотоод аппаратаараа дамжуулан хийсэн байдаг. Н.Чаушеску тэргүүтэй РКН-ын удирдагчид ЗХУ болон “социалист хамтын нөхөрлөлийн орнуудын” чиг шугамаас ангид байр суурь баримталж, Хятадын улаан хамгаалагчидтай үгсэн хуйвалдаж, нэг хүнийг дахин шүтэх, гэр бүлээрээ шүтүүлэх бодлогод автсан тухай БНМАУ-д битүү сурталчилж, МАХН-ын Улс төрийн товчоо нууц тогтоол удаа дараа гаргаж байсан бол БНСРУ-д Монгол Улс Зөвлөлтийн гар хөл, нэг ёсны колони болж, Цэдэнбал, түүний орос гэргий Анастасия Ивановна нар даварч гүйцэн, энэ улс мөлжигдөн хоцрогдож буй тухай ярьж байжээ. Энэ бүх байдал Монгол, Румыний харилцаанд сэв суулган хүйтрүүлж, үнэн хэрэгтээ үл итгэх, бие биеийг хардаж сэрдэх уур амьсгал буй болгосон юм. Харин ЗХУКН дэлхийн коммунист хөдөлгөөний

удирдагчийн хувьд Румынийг системээсээ хөндийрүүлэхгүй байх чиг шугам 1970-аад оны дунд үеэс баримтлах болж, Монгол, Румыний харилцаа ЭЗХТЗ-ийн уялдуулан зохицуулсан бодлогын хүрээнд хүссэн хүсээгүй урагшилж байлаа. ЗХУКН ийм чиг шугам баримтлах болсон нь хоёр системийн хямрал, зөрчил тэмцлийн үед АНУ тэргүүтэй өрнөдийн зүгээс авч байсан арга хэмжээтэй шууд холбоотой байв.

БНХАУ, Румын, Югослав Зөвлөлтийн талыг хэт барьсан бодлогоос татгалзаж, бие даасан дотоод, гадаад бодлого явуулах болсныг Өрнөд шууд дэмжиж, тэднийг татах зүсэн бүрийн арга хэмжээ авч байлаа. БНХАУ-д Р.Никсон 1972 онд, Ж.Форд 1975 онд түүхэн айлчлал хийж байсан бол Румынд Р.Никсон мөн анх удаа айлчилж, Чаушескугийн гадаад бодлогыг дэмжиж буйгаа илэрхийлэн, энэ улсад худалдааны нэн таатай нөхцөл хүртэл олгож байв. Социалист хамтын нөхөрлөлийн орнууд гэж байснаас Румын улс анх удаа ОУВС-гийн бүрэн эрхт гишүүн болж, зээл тусламж авч эхэлсэн байлаа. Н.Чаушеску Английн хатан хааны хүндэт зочин болж, Өрнөд тэр чигээрээ түүнийг дэмжиж байв. Энэ болгон Чаушескуг ихээхэн урамшуулж, тэрээр Монгол битгий хэл ЗХУ-ын удирдагчдын өмнөөс “цор цор” хийхэд хүргэж байсан үе бий.

Хүйтрэлийн жилүүдэд Монгол, Румыний харилцаа аажим боловч урагшилж, худалдааны эргэлт 20 сая орчим шилжих рубльд хүрсэн бөгөөд эдийн засгийн хамтын ажиллагааны чиглэлээр манай улсад сүлжмэлийн бага оврын үйлдвэр ашиглалтад орсноос өөр онцгой үйл явдал болоогүй байна. Харин Румыний техник технологи, зээлийн хөрөнгөөр барьсан Улсын циркийн барилга манай нийслэлийн нүүр царайг чимсэн гэж хэлж болно. Энэ жилүүдэд манай улсын 20 орчим оюутан Румынд төрөл бүрийн мэргэжлээр суралцаж байв.

Өөрчлөлтийн жилүүд

1982 онд ЗСБНХУ байгуулагдсаны 50 жилийн ойг Москва сүр дуулиантай тэмдэглэсэн билээ. Энэ үеэр Кремлийн Их ордонд болсон баярын хуралд манай Цэдэнбал дарга Чаушескутэй мөр зэрэгцэн суужээ. Урьд нь ЗХУКН-ын Их хурал зэрэгт ч мөн мөр зэрэгцэн сууж таардаг байсан гэдэг. Энэ удаа харин Чаушеску санаачлага гаргаж, Цэдэнбал даргатай 1971 оноос хойш анх удаа ам нээн, түүнийг гэргийн хамт Румынд айлчлахыг урьжээ. Ийнхүү 1983 оны 6 дугаар сард Ю.Цэдэнбал тэргүүтэй БНМАУ-ын нам, төрийн төлөөлөгчдийн Румынд 26 жилийн дараа хийсэн айлчлал хэрэгжсэн түүхтэй. Ю.Цэдэнбал, түүний гэргийд Н.Чаушеску өөрөө биечлэн анхаарал тавьж, улс төрийн маргаан мэтгэлцээнээс аль болох зайлсхийж байсан тул энэ удаагийн албан ёсны айлчлал тун амжилттай болж, хоёр ахмад коммунист удирдагч ч цайрсан билээ. Харин энэ үйл явдлаас нэг жилийн дараа буюу 1984 оны 8 дугаар

сард МАХН, БНМАУ-ыг 44 жил халаа сэлгээгүй удирдсан Юмжаагийн Цэдэнбалыг албан тушаалаас нь зайлуулсан бүлгээ.

1980-аад оны дунд үеэс Монгол, Румыний харилцаа илэрхий идэвхжиж, Улаанбаатар хотноо Румыний техник, эдийн засаг, 44 сая шилжих рублийн зээлийн хөрөнгөөр Мебель-картоны комбинат барьж байгуулах нүсэр ажил өрнөсөн юм. Үүнд Н.Чаушеску өөрөө их ач холбогдол өгч анхаарал тавьж байсан гэж тэр үед Монголд айлчилсан Румыний зарим удирдах нөхөд ярьдаг байсныг санаж байна. Манай удирдагчид ч румын мебелиэр ард түмнээ хангаж, бүр ЗХУ-ын Сибирт экспортод гаргах тухай мөрөөддөг байлаа. Румыний олон арван мэргэжилтэн, Монголын цэргийн барилгачдын нөр их хүч хөдөлмөрөөр барьж байгуулсан, дотроо 4 ч билүү үйлдвэрийг багтаасан Монголдоо л нүсэрт орох энэ үйлдвэр 1988 онд нээлтээ хийсэн. Мод боловсруулах үйлдвэрийн инженер, техникийн чиглэлээр тэр жилүүдэд Монгол Улс Румынд 20 гаруй оюутан сургаж бэлтгэсэн билээ. Харамсалтай нь тэдгээр мэргэжилтнүүдийн заримын овсгоо самбаа, оролцоотойгоор дурдсан том үйлдвэр 90-ээд оны сүүлчээр их хувьчлалын давалгаанд өртөн үрэн таран болж нүд аньсан юм. Үүнээс Монголын ард түмэн л хохирч Румынд өртэй үлдсэн бөгөөд энэ нь эдүгээ нэхэгдэж буй билээ.

Н.Чаушеску гэргийн хамт 1988 онд мөн л БНХАУ, БНАСАУ-д айлчлахдаа Монголын шинэ удирдагч Жамбын Батмөнхтэй нүүр тулан уулзаж, Цэдэнбалаас хойшхи хоёр орны харилцааны хэтийн төлвийг хэлэлцэхээр Монгол оронд албан ёсны хоёр дахь айлчлалаа хийв. Айлчлал амжилттай болж, тэрээр Сүхбаатарын одонгоо зүүж, Улаанбаатарт ЭСЯ-ныхаа барилгыг барих газрыг хүртэл товлон зааж өгснөөр сэтгэл нэн хангалуун нутаг буцсан билээ. Гэвч тэрээр Монгол оронд дахин ирэхгүйгээр явж буйгаа төсөөлөөгүй юм.

Өөрчлөн байгуулалтын их давалгаа коммунизмын мөхлийг зөгнөсөн тэр жил буюу 1989 оны 12 дугаар сарын Румыний ардчилсан хувьсгалаар РКН, БНСРУ-ыг тасралтгүй 24 жил удирдсан Николае Чаушеску гэргий Еленагийн хамт эмгэнэлтэйгээр цаазлуулснаар хорьдугаар зууны Монгол, Румыний коммунист харилцааны түүхэнд ч нэгэн адил цэг тавигдсан ажгуу.

Зах зээлийн жилүүд

1990-ээд онд зогсонги байдалд орсон харилцаа 1991 оноос сэргэж, улс төрийн яриа хэлэлцээ үргэлжилж, эхэлснээс гадна зах зээлийн харилцааны үндэс суурийг тодорхойлох зарим гэрээ хэлэлцээр байгуулагджээ.

Монгол Улсын УИХ-ын дэд дарга, Гадаад харилцааны дэд сайд нар 1995 онд Румынд, Румыний ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга 1991

онд Монголд тус тус айлчилсан байна. 1994–1997 онд хоёр улсын хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа идэвхтэй өрнөж, Үндсэн хуулийн цэцийн болон Дээд шүүхийн дарга нар харилцан айлчилжээ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тусгай чуулганы хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайд, Румыний Ерөнхийлөгч нар 2001, 2002 онд тус тус уулзаж, хоёр улсын харилцааг цаашид хөгжүүлэх боломжийн тухай зөвлөлдсөн нь хоёр талын хооронд олон жил завсарласан дээд хэмжээний хэлхээ холбоог сэргээхэд чухал ач холбогдолтой болсон гэж үзэж болно. 2005 онд манай ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Румынд айлчилж, зөвлөлдөх уулзалт хийв.

Энэ хугацаанд хоёр орны хооронд Төлбөрийн харилцаанд харилцан хүлээх үүргийг зохицуулах тухай, Худалдааны төлбөрийн тухай, Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих тухай зэрэг хэлэлцээрүүдийг тус тус байгуулсан нь худалдаа, эдийн засгийн харилцаа хөгжих үндэс суурь болж буй юм. Мөн 2005 оны 2 дугаар сард Монгол, Румыний хооронд соёл, боловсрол, ШУТ-ийн салбарт хамтран ажиллах Хэлэлцээрийг шинэчлэн байгуулжээ.

Зах зээлийн эдийн засагт шилжих үеийн бэрхшээл зовлонгоос шалтгаалан Румын улс 1995 онд Улаанбаатар дахь Элчин сайдын яам \ЭСЯ\ -аа, Монгол Улс 1997 онд Бухарест дахь ЭСЯ-аа тус тус хаасан билээ. Энэ нь үнэн чанартаа харилцаа, хамтын ажиллагааны түүхэнд нэг алхам ухралт болсон юм. Харин хориннэгдүгээр зууны Монгол, Румыний харилцаа цаашид хэрхэн өрнөхийг өнөөдөр төсөөлөн хэлэх аргагүй билээ.